

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№3 (1)

2021.04.12

УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ МЯНГАНЫ СОРИЛТЫН ХОЁР ДАХЬ КОМПАКТ ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР ХЭРЭГЖИЖ ЭХЭЛЛЭЭ



Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорацын хооронд байгуулсан Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээ 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хүчин төгөлдөр болж, Компакт гэрээний 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх таван жилийн хугацаа албан ёсоор тоологдож эхэллээ. Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорац нь Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээ буюу Усны Компакт гэрээнд 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурсан. Компакт гэрээний санхүүжилтээр нийслэл Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах ус хангамжийн шинэ эх үүсвэрүүд, Монголд анх удаа ус гүн цэвэршүүлэх болон хаягдал ус дахин боловсруулах хоёр томоохон үйлдвэр байгуулахаас гадна ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний байгууллагуудын институцийн чадавхыг бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг сайжруулах замаар усны салбарын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ. Ингэснээр 2026 он гэхэд Улаанбаатар хотын ус хангамж 80 гаруй хувиар нэмэгдэж, нийслэл хот баруун тийш өргөжин тэлэх, тэр чинээгээр эдийн засаг өсөх таатай боломж бүрдэх юм.

[Эх сурвалж: Монголын Мянганы сорилтын сан](#)

ДАРХАНЫ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ 70 ХУВЬТАЙ ЯВАГДАЖ БАЙНА



Барилга, хот байгуулалтын яам 10 гаруй аймгийн цэвэрлэх байгууламжийн технологи, барилга байгууламжийн төслийг хэрэгжүүлэхийн дотор Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, насос станцын шинэчлэлийн ажлыг хийж байгаа билээ. Энэ хүрээнд нийт 41 барилга байгууламжийг шинээр барьж угсарна. 2021 оны 1-р улирлын байдлаар 19 байгууламжийн барилга угсралтын ажил дуусч, 13 байгууламжийн барилга угсралтын ажил үргэлжилж байна. Тодруулж хэлбэл, төслийн нийт барилга угсралтын ажлын явц 70%-тай байгаа аж. Үүнээс гадна Азийн хөгжлийн банкны нэмэлт санхүүжилтийн зээлээр Архангай, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай, Булган, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Сүхбаатар зэрэг нийт есөн аймгийн цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төслийн барилга угсралтын ажил ирэх намар дуусах юм байна. Түүнчлэн Улаанбаатар хотын шинэ Төв цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлыг Засгийн газрын өгсөн үүрэг даалгавар болох 55 хувиас давуулж гүйцэтгэхээр ажиллаж байгаа талаараа тус төслийг хэрэгжүүлэх нэгжээс мэдээлжээ.

[Эх сурвалж: БХБЯ, Шинэ төв цэвэрлэх байгууламжийн төсөл хэрэгжүүлэх нэгж](#)

“ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ” БАЙГУУЛЛАГААС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛНЭ

“Дэлхийн Зөн Монгол” Олон Улсын Байгууллага нь КОВИД -19 цар тахалтай холбогдуулан “Хамтдаа даван туулья” төслийг нийслэлийн СХД, СБД, БЗД, Баян-Өлгий, Өвөрхангай аймгуудад хэрэгжүүлж байгаа бөгөөд тус төслийн “Ус орчны эрүүл ахуй” зорилтын хүрээнд ариун цэврийн байгууламжийн төсөл хэрэгжүүлэх аж. Энэхүү төслөөр алслагдсан сумын нэг сургуулийн дотуур байрны ариун цэврийн байгууламжийг шинээр барих, зорилтот бүлгийн 18 өрхөд эко ариун цэврийн байгууламж шинээр барих, зорилтот бүлгийн 100 өрхийн ариун цэврийн байгууламжийг нөхөн сэргээж засварлах, өрхийн ариун цэврийн байгууламжийн ашиглалт, арчилгааны талаар олон нийтийн мэдлэг мэдээллийг сайжруулах сургалтууд зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх юм байна.

[Эх сурвалж: Дэлхийн Зөн Монгол](#)

ТОВЧХОН

- Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжид **хоногт 1600 кг усанд уусдаггүй хог** ирдэг нь Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байна. [Эх сурвалж: ТВ-8 телевиз](#)
- Монгол орны гадаргын усны нөөцийн 70 гаруй хувийг дангаараа бүрдүүлдэг Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргаа нь орон нутгийн Татварын хэлтэстэй хамтран усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн **ус ашигласны төлбөрийн** жишиг үнийн дүнг аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдаанаар батлуулжээ. Ингэснээр байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлбөрийн орлого нэмэгдэх, Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт хангагдах юм. [Эх сурвалж: МУ-ын Усны салбар хуудас](#)
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дүгнэлтийг үндэслэн “Шинь Шинь ХХК”-тай **ус бохирдуулсны төлбөрийн** тухай хуулийн дагуу хаягдал ус зайлуулах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав. Энэхүү төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн усны бохирдлыг арилгах, нөхөн сэргээх, цэвэрлэх байгууламжийн засвар үйлчилгээнд зарцуулах юм. [Эх сурвалж: МУ-ын Усны салбар хуудас](#)
- Олон улсын усны холбооноос **Дэлхийн Усны Конгрессыг** 2021 оны 5 дугаар сарын 24-нөөс 6 дугаар сарын 4-ний хооронд анх удаа цахимаар зохион байгуулна. [Эх сурвалж: Олон улсын усны холбоо](#)
- Дэлхийн усны салбарын хамгийн нэр хүндтэй, 115 000 ам.долларын мөнгөн шагнал дагалддаг **"Стокхольмын олон улсын усны шагнал"**-д салбарын эрдэмтэн, судлаачдаас гадна усны нөөцийг хамгаалах, цаашлаад эх дэлхийн сайн сайхны төлөө ажиллаж буй хувь хүн, байгууллага нэрээ дэвшүүлэх боломжтой юм байна. [Эх сурвалж: Стокхольмын олон улсын усны институт](#)